

ЗҮҮНГАРЫН ГОВИЙН ТАХИЙН МЭДЭЭ



2016 оны 6-р сар

Монгол тахь эх нутагтаа – Бидний туршилт



**Тахь болон түүний амьдрах
орчныг хамтдаа хамгаалцгаая**

Тахийг хайрлан хамгаалдаг эрхэм андууд аа!



Зэрлэг адуу буюу монголоор тахь нь панда шиг ховордсон амьтан бөгөөд хүмүүс тэр бүр мэддэггүй. Тахь нь төв азийн тал хээрийн бэлэг тэмдэг болсон амьтан бөгөөд байгальдаа устаад байсан боловч хүний оролцоо дэмжлэгээр нутагтаа эргэн нутагшаад байна. Олон мянган жилийн өмнө энэ амьтан Атлантикаас Зүүн ази хүртэлх өргөн уудам нутагт тархан амьдардаг байсан ба үүний баталгаа нь эртний хүмүүс

Ласка, Алтамирагийн агуйн ханан дээр тахийг зурж үлдээсэн явдал юм. Хүмүүсийн ан ав хийх аргачлал нь боловсронгуй болох тусам зэрлэг тахь хорогдсоор байсан юм. Зэрлэгээрээ байсан сүүлчийн адуу нь Монголын баруун өмнөд хэсэг Зүүнгарын говьд амьдарч байсан бөгөөд 1960 аад оноос байгальдаа үзэгдэхээ больсон гэдэг. Гэвч 100 гаруй жилийн өмнө энэ тал нутгаас Европруу гаргасан тахийн үр удам нь амьтны хүрээлэнд мөхөж, усталгүйгээр үлдэж хожим эх нутаг нь буцаан зэрлэгшүүлэх ажлын үндэс болж чадсан юм.

Зүүнгарын говьд тахийг сэргээн нутагшуулсан анхны үйл ажиллагаа нь алсын хараатай, сайн дурын хэсэг хүмүүсийн дэмжлэгтэйгээр хийгдсэн ба үүнд Кристиан Освальд, Жан-Пиер Зийгфрийд, Доротте Штамм болон Очирын Доржраа нарыг юун түрүүнд дурьдах нь зүйтэй. Эдгээр хүмүүс энэхүү буянт ажлыг санаачлан, санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон бодитоор гар бие оролцсон юм. Европ, Монголын байгальд элэгтэй, байгаль хамгаалагч нарын хичээл зүтгэлээр их хүнд сорилтыг даван, бараг л боломжгүй гэгдэж байсан тахь сэргээн нутагшуулах төслийг амжилттай хэрэгжүүлж чадсан. Энэ ажлыг эхлүүлэх үед "Амьтны хүрээлэнд идээшиж дассан амьтан хатуу, ширүүн уур амьсгалтай орчинд тэсвэрлэж чадах байсан болов уу?" гэсэн хүндэн асуудал тулгарч байсан ч одоо эсрэгээрээ тахийн тоо толгой уугуул нутагтаа амжилттай дасан нутагшиж 120 орчим тоо толгой болсон бөгөөд энэ жил бид 50 орчим гүү унагалахыг тэсэн ядан хүлээж байна. Ингэснээр Зүүнгарын говийн тахийн тоо толгой 170 орчим болох сайхан мэдээтэй байна. Ирээдүй их сайхан харагдаж байгаа ч одоогоор 170 толгой тахь гэдэг бол энэ амьтан байгальдаа хүний оролцоогүйгээр биеэ даасан зэрлэг сүрэг болон цааш өсөн үржихэд хараахан хангалттай тоо биш юм. Тэдний ирээдүй дээсэн дөрөөн дээр байна. Хятадын баруун хойно байрлах Каламайли байгалийн нөөц газарт 150, Монгол орны төв хэсэг Хустай байгалийн цогцолбор газарт 350, Хомын талд 50 толгой тахь байгаа хэдий ч хоорондоо алслагдсан, тусгаарлагдсан популяциуд бөгөөд тоо толгойн хувьд ч хангалттай түвшинд хүрээгүй л байна. Дээрх тусгаарлагдсан популяциудийн амьдрах орчинг тэлж, хооронд нь холбож, зориудаар цус сэлгэн үржүүлсэн тохиолдолд л тахийн тогтвортой сүрэг бий болон өсөх боломжтой. Төв азийн тал хээр нутгийн ургамал, амьтны хувьд ч ялгаагүй энэ зарчим үйлчилнэ. Эдгээрийг холбох, ойртуулах хэтийн зорилго нь хэрэгжүүлж болохуйц ба энэ нь байгаль орчныг хамгаалах, тэр дундаа Зүүнгарын говийн бүс нутгийг бүхэлд нь хамгаалах бидний гол зорилгуудын нэг яах аргагүй мөн юм. Тахь болон түүний амьдрах орчныг бид байгальд элэгтэй олон хүний дэмжлэг ялангуй тухайн нутаг орны иргэд, малчдын оролцоотойгоор хамтдаа хамгаалах нь бодит үр дүнг бидэнд авчрах юм.

Райнхард Шнидрих



20'000 жилийн өмнө тахь Еворази даяар тархсан байжээ. Гэвч 1960 онд дэлхий даяар зөвхөн 12 тахь үлдсэн байв.

Амьдрах орчныг холбох

Дэлхий дээр нийт 2000 орчим толгой тахь амьтны хүрээлэн, тахь үржүүлгийн газар болон хамгаалалттай нутгуудад амьдарч байна. Монголын тухайд хамгийн олон тахьтай улс бөгөөд Зүүнгарын говь буюу Говийн их дархан цаазат газрын /ГИДЦГ/ "Б" хэсгийн 9000 км² талбай бүхий нутаг, Хустайн байгалийн цогцолборт газрын уулсаар хүрээлэгдсэн тал хээрийн 500 км² талбайтай нутаг мөн Хомын талын 14000 га талбайд нийт 500 гаруй нутагшиж байна. Энэ нь Хятадын баруун хойд хэсгийн говь, Зүүнгарын сав газрын Каламайлигийн хамгаалалтын бүсийн гуравны нэгтэй дүйцэхүйц бага талбайтай юм. Эдгээр газар нутгууд хоорондоо хэдэн зуун километрээр алслагдсан. Хустай нь хамгийн зөөлөн, дулаан уур амьсгалтай ч мал аж ахуй эрхэлсэн нүүдэлчдийн дунд хэсэгт оршдог. Харин ГИДЦГ болон Каламайли бүс нь экологийн хувьд төсөөтэй юм. Төв Азийн онгон зэлүүд нутаг нь ан амьтан идээшиж, нутаглахад тохиромжтой дэлхий дээрх хамгийн том тал хээр, говь, уулархаг нутаг цогцолсон газар юм. Жишээ нь бөхөн, хар сүүлт зээр, аргаль, янгир, хулан, тахь зэрэг амьтдын тархац нутгийн нэлээд хэсэг нь хамгаалагдсан бүсэд хамрагдаж байдаг. Дээрх ховор хөхтөн амьтдын амьдрах орчныг хамгаалах нь Төв Азийн Хөхтөн Амьтдыг хамгаалах Санаачлага (Central Asian Mammals Initiative-CAMI) байгууллагын гол зорилго юм.

Олон улсын тахь групп болон Төв Азийн Хөхтөн Амьтдыг хамгаалах Санаачлага байгууллагууд нь ерөнхийлөгчөөрөө дамжуулан холбоотой ажилладаг. Бид Монгол, Хятадын төрийн албаныхантай хийж буй уулзалтаараа Монгол Алтай Говийн их дархан газар болон Хятадын Шиньжан мужийн хилийн зурвас, тороор хязгаарлагдсанаас зэрлэг амьтад чөлөөтэй нэвтэрч чадахгүй байгаа нөхцлийг цаашид хялбаршуулах, чөлөөтэй нэвтрүүлэх тал дээр ярилцан ажиллаж байна.

Олон улсын тахь группын зорилго

- Говийн Их Дархан цаазат газрын "Б" хэсгийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр өргөн хүрээнд судлах, хамгаалах
- Урт хугацаанд байгальд амьдрах чадвартай тахийн сүргийг бий болгох
- Байгалиа хамгаалахад тухайн орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

Таны тусламж бидэнд хэрэгтэй

Хандив өгөх хүсэлтэй хэн бүхэнд нээлттэй. Таны өгсөн хандивыг бид юунд үр дүнтэй зарцуулахаар төлөвлөж буйг та эндээс харна уу.



40 000 төгрөг

Хамгаалагчийн нэг өдрийн хөлс (Цалин, материалын зардал)



410 000 төгрөг

Сарын турш сансарын интернэт ашиглах зардал



200 000 төгрөг

5 метрийн урттай хашааг дахин засварлах эсвэл нэг тахийг өвлийн хүйтэнд хооллох өвс тэжээл



400 000 төгрөг

Хамгаалалттай бүсийн баруун хэсэгт тахийг нутагшуулах, дасан зохицоход зориулсан 5 м урттай хашаа барих



500 000 төгрөг

Байгаль хамгаалагчийн нэг сарын унааны зардал



10 000 000 төгрөг

Тахийн сүргүүдийн нэг өвөлд зориулсан өвс тэжээл

Олон улсын тахь групп нь сайн дурын (цалин авдаггүй) байгууллага бөгөөд таны өгсөн хандив зөвхөн тахь хамгаалах ажилд зарцуулагдана.

“Тахийн нөхөд” санд гишүүнчлэлээр элсэхийг хүсч байна уу?

Хувь хүний жилийн татвар **100 000** төгрөг.

Хүүхэд багачуудад зориулсан “Унага- Гишүүнчлэл”- оюутан, сурагчид **20 000** төгрөг.

Худалдаа хөгжлийн банк

Данс эзэмшигч: Олон улсын тахь группын Монгол дахь товчоо

Данс: 499114883

Олон Улсын Тахь Группт БНХАУ-ыг элсүүлэх



Шиньжаны
“Экологи, Газарзүйн
Институт”-ын
профессор

ЯНГ ВЭЙКАНГ

БНХАУ-ын баруун хойно орших автономат муж болох Шиньжанд тахийг өсгөж үржүүлэх, мөн байгальд сэргээн нутагшуулах хөтөлбөрийг сүүлийн 30 шахуу жилийн турш Хятадын төрөөс дэмжин хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ үйл ажиллагаанд олон улсын тахь групп төдийг идэвхтэй оролцож байгаагүй юм. Өнгөрсөн 2015 оны намар олон улсын тахь группын төлөөлөгч нар Жимсарын тахь үржүүлгийн төв болон Каламайлийн нөөц газарт зочилсон бөгөөд албаны холбогдох хүмүүсийн уулзалтын үеэр Шиньжаны “Экологи, Газарзүйн Институт”-ын профессор Янг Вэйканг „Бид Олон Улсын Тахь Группт элсэхээ тэсэн ядан хүлээж байна” хэмээн бидэнд хэлж байлаа. (Зүүн гар талын зураг).

Шиньжанд байрлах тахь нутагшуулах төслийн нарийн бичгийн дарга Ши Жүн “Бидэнд Жимсар дах тахийн популяцийн цусыг сэлбэхийн тулд азарга яаралтай хэрэгтэй мөн Олон улсын тахь группээс тахь үржүүлэх, нутагшуулах тал дээр туршлага судлах хамтран ажиллах нь бидэнд маш чухал юм” хэмээн онцолсон юм. Одоогийн байдлаар Хятадын байруун хойд Шиньжан мужид 340 орчим тахь байгаагаас Жимсарын тахь үржүүлгийн газарт 90, Өрөмч хотын 75 км² талбайтай амьтны хүрээлэнд 90, Жимсараас зүүн хойшоо гурван зуун км зайд орших Каламайлийн байгалийн цогцолборт газарт 150 гаруй тоо толгой тахь нутагшиж байгаа юм байна.

Сэргээн нутагшуулах хөтөлбөрийг хооронд нь уялдуулах, илүү сайн холбож өгөхийн тулд олон улсын тахь группын хувьд Хятадыг элсүүлэх нь чухал юм. Ийм ч учраас Хятадын байгаль хамгаалах албаныханд ойлгомжтой байх үүднээс Өрөмч хотод талууд хоорондын урт хугацааны хамтын ажиллагааны хэлэлцээрийн асуудлыг боловсруулан гаргасан. Бидний хамтын ажиллагаа, зорилтын алсын харааны нэг бол хил дамнасан хамгаалалтын бүсийг бий болгоход Хятадтай урт хугацаанд хамтран ажиллах явдал юм.

ГЕНИЙН СОЛИЛЦОО

Аливаа сүргийн генийн солилцоо бага байх нь үржлийн үйл явцийг эрсдэлд оруулах аюултай. Тийм ч учраас дэлхий дээрх цөөн тоотой тахийн сүргийн хувьд генийн солилцоог тогтмол хийж байх нь чухал бөгөөд Зүүнгарын тахийн популяцийн генийн удмийн санг сайжруулах зорилтот ажлын хүрээнд 2016 онд Праг хотын амьтны хүрээлэн, Хустай нурууны байгалийн цогцолборт газар болон БНХАУ-ын Жимсарын тахь үржүүлгийн газруудаас тахь тээвэрлэн авчрах бэлтгэл ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд тээвэрлэлтийг 7-р сард хийнэ. Энэхүү шинээр тээвэрлэн авчирсан тахиудыг ГИДЦГ-ын “Б” хэсгийн тахь нутагшуулах төвд дасгах хашаанд нэг жил орчим ажиглалт, хяналтанд байлгаад говийн уудам бэлчээрт нь суллан гаргадаг.

Тахийг улс, хил дамнуулан тээвэрлэхэд асар их зардал, хүч хөдөлмөр ажиллагаа шаардаг ба тэднийг бат бөх хашаанд дасган ажиглалт хийхэд чамгүй их ажиллагаа зардал хэрэгтэй байдаг.



“Хустай Байгалийн Цогцолборт газар”-ын тахийн бэлчээр (Монголын хойд хэсэг, дээд талын зураг), Говийн Их Дархан Цаазат Газрын “Б” хэсэг (дунд талын зураг) болон Каламайли Хамгаалалтын Бүс (БНХАУ-ын Шиньжан муж, доод талын зураг) нь хоорондоо их ялгаатай.

Хамтарсан сургалт: Монгол-Хятадын хамтарсан дадлага олгох сургалт

Тахийг говь хээрийн бүсэд нутагшуулах гэж буй бол үржүүлгийн газарт хүнс тэжээлээр хэрхэн хангаж хооллох вэ? Тээвэрлэх явцад туурайнаас авхуулаад шимэгч хорхой, цаашлаад стрессээс урьдчилан сэргийлэх зэрэг тахийн эрүүл мэндийн байдлыг хэрхэн нягталж, анхаарах вэ? Алслагдсан, аль болох хол удамтай сүргийг хэрхэн нийцүүлэх вэ? Суллан тавихад ямар орчин тохиромжтой вэ? Тахийг тээвэрлэх хайрцагт хэрхэн байрлуулах вэ, хүрэхэд хэцүү бүсэд аваачихад хайрцаг сав нь ямар байвал тохиромжтой байх вэ? Идээшиж, нутагшихад хэр удаан хугацаа шаардагддаг вэ? Сул тавьсны дараа хэрхэн идээшин дасаж буй эсэхийг хэрхэн харж ажиглах, хамгаалах вэ, нутагшуулж буй тахийг ямар нөхцлөөр эргэн дэмжих вэ? Сүрэг хэрхэн, яаж үржин өсөж буйг хэрхэн ажиглаж, мэдэх вэ? Унагыг махчин амьтнаас хамгаалах хэрэгтэй юу? Амьтны хүрээлэнд дассан амьтныг сул чөлөөтэй байлгахдаа хэрхэн, яаж биеэ хамгаалж, бие даан амьдрах чадвартай болгох вэ?

Эдгээр асуултыг асуухад амархан ч шийдлийг олох нь тийм ч хялбар биш юм. БНХАУ-ын Жимсарын тахь үржүүлэх төв нь олон улсын тахь групп, говийн тахь нутагшуулах төвийн хамгаалагч нар өөрсдийн хуримтлуулсан үнэт туршлага, мэдээллийг харилцан солилцох хүсэлтэй байгаа нь ойлгомжтой. 2016 онд ГИДЦГ-ын “Б” хэсгийн хамгаалалтын захиргаан дээр талуудын хамтрсан онол практикийн сургалт зохион байгуулахаар төлөвлөж байгаа нь хоёр улсын байгаль хамгаалагч, тахь судлаач нарт харилцаа холбоо шууд тогтоох, туршлага солилцох, харилцан найрсагаар биенээ хүлээн авах зэрэг таатай уур амьсгалыг бий болгох учиртай юм.



Хятадын Жимсарын тахь үржүүлэх төвийн ажилтан **ВАНГ ЦЭНШАН**

Энэ жил говьд болох Монгол-Хятадын тахь хамгаалагч нарын хамтарсан сургалтыг ихэд сонирхож байна.



Жимсар дахь тахь үржүүлгийн төвийн хашаанд байрлаж буй тахиуд (Хятадын баруун хойно байрлах Шиньжан муж)

Судалгаа, шинжилгээ

Зүүнгарын говийн экосистемийн талаарх бидний мэдлэг мэдээлэл тогтмол дээшилсээр байна. Энэ бүс нутгийн экосистемийн талаарх ойлголтийг дээшлүүлэхэд Австри улсын Венийн мал эмнэлгийн их сургуулийн профессор Кристиан Валцер болон амьтан судлаач, доктор Петра Каченски нарын хувь нэмэр голлох үүрэг гүйцэтгэсэн. Тэд говийн экосистемийн судалгаа тахь, хулан болон хавтгай тэмээний экологийн судалгааны ажлуудын мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж ирсэн нь олон улсад үнэлэгдсээр байна. Олон улсын тахь группын нэг зорилго бол эрдэм шинжилгээний суурь судлагдахуун дээр үндэслэн байгаль хамгаалах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх явдал бөгөөд судалгааны ажлыг идэвхтэй дэмжин ажиллаж байна. ГИДЦГ-ын “Б” хэсэг хамгаалалтын захиргаа нь олон улсын тахь группын удирдлаган дор О. Ганбаатараар ахлуулан мэрэгч амьтан, махчин шувуудын экологи, хулан, тахийн зан төлвийн талаар судалгааг гадаад, дотоодын оюутнуудын оролцоотойгоор хийж байна. БНХАУ-д профессор Янг Вэйканг (Шиньжаны Экологи, Газарзүйн Институт) махчин амьтад, цагаан зээр, говийн заг модны (*Haloxylon ammodendron*) экологи болон ганд тэсвэртэй бут модны гидрологи болон тухайн нутгийн төрөл зүйл амьтад үзүүлж буй томоохон ач холбогдолын талаар судалж байна.

Байгаль хамгаалагчтай хийсэн ярилцлага: Оюунсайханы ГАНБААТАР

Оюунсайханы Ганбаатар нь Говийн их дархан цаазат газар/ГИДЦГ-ын "Б" хэсэг, Алагхайрхан уулын байгалийн нөөц газрын хяналт шалгалт, судалгаа шинжилгээ харуулсан Хамгаалалтын захиргааны дарга ба түүний удирдлаганд 3 мэргэжилтэн, 7 байгаль хамгаалагч, 3 аж ахуйн ажилчид ажилдаг. Тэрээр Улаанбаатар хотод МУИС-ийг биологич мэргэжлээр 1999 онд төгссөн бөгөөд ажлынхаа хажуугаар Зүүнгарын говьд сэргээн нутагшуулсан тахийн судалгааны ажлаар эрдмийн зэрэг горилсон бүтээлээ боловсруулж байна.



ОУТГ: Ганбаатараа ГИДЦГ-ын "Б" хэсэг, түүний орчны бүсэд өвөл хэрхэн болж өнгөрөв, сэргээн нутагшуулж буй тахийн сүргүүд өвлийг хэрхэн давсан бэ?

О.Ганбаатар: Цас харьцангуй ихтэй байсан ч ерөнхийдөө өвөлжилт сайхан болж өнгөрлөө. Энэ өвлийг 2009/2010 оны өвлийн зудтай харьцуулахааргүй өнтэй жил боллоо. Тэр өвөл маш их цас орж, эрс хүйтэрсний улмаас бараг 8 мянган толгой мал манай дархан газар, түүний орчны бүсэд үхэж үрэгдсэн. Цаг агаарын нөхцөл байдал үнэхээр ширүүн, тухайн үед нутагшуулж байсан тахийн бараг тэн хагас нь үрэгдэж, цөөрсөн жил байсан. Ийм байдлаар цаг агаар ирээдүйд хүндэрвэл цөөн тоо толгойтой манай тахийн хувьд хамгийн том аюул занал болох бөгөөд тухайн нөхцөлд тахийг тоолох, ажиглах, хамгаалахад бидний зүгээс нэлээд их хүч хөдөлмөр шаардлагатай болдог. Азаар маш их хүйтэрдэг хэмээн настай хүмүүс хэлэлцдэг бичин жилийн толгой өвөл гайгүй, сөрөг юм гарсангүй, харин төгсгөлдөө буюу сүүлэндээ яадаг бол. Энэ хавар 3-р сарын сүүлийн хагасд бороо, цас нэлээн орсон нь өвс, ургамал эртхэн ургахад их сайнаар нөлөөллөө. Бэлчээр эрт сэргэх нь говь, талын өвсөн тэжээлт зэрлэг амьтны тоо толгой асахад нэг чухал хүчин зүйл болж байдаг л даа.

ОУТГ: Тахийн сүрэг хэр өсөж байна вэ?

О. Ганбаатар: Маш сайн байгаа. Тахийн тоо толгой 2015 оны намар 2009 оны жилийн эцсийн тоотой ойролцоо буюу 132 тоо толгойд хүрсэн. Харин 2016 оны хаврын ажиглалт судалгаагаар 50 гаруй гүү хээл авсан гэж тогтоов. Олон унага төрнө гэж бид найдаж байна. Нийт тахийн 2/3 нь үржлийн насны гүү байх нь тахь хурдан өсөхөд нөлөөлнө.

ОУТГ: ГИДЦГ-ын "Б" хэсгийн баруун хойд цэгт орших Тахийн усанд нутагшуулж байгаа цөөхөн тоотой тахийн сүрэгт чонын аюул их байна, ялангуяа унага их өртөж байна.

О. Ганбаатар: Бид олон улсын тахийн групптэй хамтран Дархан цаазат газарт хуулийн хүрээнд хэрэгжүүлж болохуйц шийдлийг хайж байна. Чоно дархан цаазат газарт хамгаалагдсан амьтан. Тухайн бүсэд байгаль хамгаалагч нарын тоог ихэсгэсэн ч үргээх тактик ашиглах нь нэлээд хэцүү байдаг. Чоно үүрлэх, гөрөөлөх газар нутгаа сайн мэддэг, ялангуяа хулан, тахь, зээрийг усанд ирэх үед нь ихэвчлэн барьдаг.

ОУТГ: ГИДЦГ-ын "Б" хэсгийн баруун бүсэд тахийн тоо толгойг ихэсгэвэл чонын аюулыг багасгаж болох уу.

О. Ганбаатар: Ер нь тахь Дархан газрын зүүн/Хонь усны баян бүрд/, баруун /Тахь ус, Ёлхон/ хэсгийг улирлын чанартай сэлгэн нутаглах хэрэгтэй, тиймээс ч бид Хонь ус, Тахь усны дунд нарны худаг байгуулсан. Баруун хэсэгт тахийн тоо толгойг нэмэгдүүлэхийн тулд энэ жил Хустайн нурууны БЦГ, БНХАУ-ын Жимсараас тахь тээвэрлэхдээ баруун бүсэд нутагшуулна. Баруун бүсэд 2012 онд Жимсараас 4 азарга тээвэрлэн нутагшуулж байсан бөгөөд энэ жил гүү авчирч нийлүүлэх хүсэлтэй байгаа.

ОУТГ: Нутагшуулахын тулд баруун бүсэд танд хашаа хэрэгтэй байх. Одоо хүртэл хашаагүй байгаа.

О. Ганбаатар: Тийм. Зүүн бүсэд байгаа хашаанаас хоёрыг буулгаж, материалаар нь баруун бүсэд дахин хашаа барина. 5,1 км урттай тороор ойролцоогоор 150 га газрыг хүрээлсэн хашаа барихад бидэнд бат бөх төмөр шон хэрэгтэй болно.

ОУТГ: Нутагшуулахад хэр хугацаа шаардагддаг вэ?

О. Ганбаатар: Хустайгаас авчрах тахинд 6-7 долоо хоног шаардлагатай болдог. Харин Прагийн амьтны хүрээлэнгээс ирж байгаа тахины хувьд хашаанд нэг жил байлгаж нутагшуулах шаардлагатай. Учир нь амьтны хүрээлэнд байсны дараа нутагшуулах нь илүү хэцүү байдаг.

ОУТГ: Баруун бүсийн тахийг ирээдүйд та өснө гэж бодож байна уу?

О. Ганбаатар: Тиймээ. Өнгөрсөн жил бид зүүн бүс Хонь уснаас баруун бүс Тахь усны хооронд, шилжилт хөдөлгөөн хийдэг нэг сүрэгтэй болсон ба энэ сүрэг нэг өдөрт заримдаа бараг 60км зайд явсаныг нь бид ажигласан. Зэрлэгшсэн сүргийн хувьд дассан газартаа байх дуртай хандлага байгаа нь биднийг санааг зовоож байсан болохоор үүнийг хараад их урам орсон. Сэргээн нутагшуулах хятадын төслийн туршлагаас харахад тахь сул тавьснаас хойш нэлээд олон жилийн дараа нутгаа сэлгэж эхэлсэн байдаг.

ОУТГ: Хятад болон Хустайгаас та ямар хүлээлттэй байна вэ?

О. Ганбаатар: Зөвхөн байгаль хамгаалагч гэлгүй туршлага, мэдлэг, үзэл бодлоо солилцох, бие биенээсээ урам зориг авахыг хүсч байна. Хүн бие биенээсээ үргэлж суралцаж байдаг. Хятадад хэрэгжиж байгаа төслийн хувьд үржүүлгийг хэвээр авч үлдэхэд гол анхаарлаа их удаан хандуулж байсан ба манайхыг бодвол нутагшуулж буй орчны хувьд хамаагүй хязгаарлагдмал юм байна лээ. Онгон байгальд байлгах туршлага, ажиглах боломж бага боловч улсаас нь хангамж хамаагүй их өгдөг. Харин хятадын байцаагч нар нутагшуулаад олон жил болсоны дараа хүртэл бүх адуу, гүүгээ таньж байгааг хараад биднийг их гайхсан. Хустай бол жуулчдынхаа орлогоор үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ нь ч манай хэтийн нэг зорилго болж байгаа. Үүнээс гадна Жимсар, Хустайн тахиудтай үржлийн удмын солилцоо хийхэд хамтын ажиллагаа их чухал юм.

ОУТГ: Та манай спонсоруудаас юу хүсч байна вэ?

О. Ганбаатар: Урт хугацааны, тогтвортой дэмжлэг. Санхүүгийн хувьд бид тийм ч чадавхтай биш байна. Уул уурхайн түүхий эд хямарснаас болоод улсаас өгдөг жишээ нь үйл ажиллагааны зардал, урсгал зардал г.м гол төсөв танагдсан. Тиймээс хөрөнгө оруулалт хийж байгаа төгрөг болгон манай хөтөлбөрт их чухал. Хөрөнгө оруулалт хийж байгаа спонсорууд өөрсдийн танилын хүрээнд энэ хөтөлбөрийн тухай танилцуулж, ярьж болно. Ирвэс аюулд өртсөнийг хүн бүр мэдэж байгаа боловч тахийн сүрэг мөн л бага гэдгийг тэр бүр хүмүүс мэддэггүй.

ОУТГ: Тахийг Монгол улсад эргэн нутагшуулахад та зүрх сэтгэлээрээ хичээн ажиллаж байна. Яагаад?

О. Ганбаатар: Тахь бол гэрийн адуутай удам нэгтэй дэлхий дээр байгаа цорын ганц зэрлэг адуу тул энэ амьтныг авран хамгаалж, өсгөн үржүүлэх нь хүн төрөлхтөн болоод МУ-ын түүхэнд маш чухал ач холбогдолтой. Биднээс хамаарч ямарч зүйл амьтан мөхөх ёсгүй. Ингэвэл хүн төрөлхтний хувьд эмгэнэлтэй үйл явдал болох юм даа!

ЭКОСИСТЕМИЙН СУДАЛГАА: ХУЛАН

Хулан (*Equus hemionus*) нь Алтайн нурууны өмнөд говиуд болон Монголын өмнөд нутаг, Хятадын баруун хойно орших Шиньжан мужийн нутагт тархан нутагладаг амьтан бөгөөд урьд өмнө нь сибирийн болон манжуур хүртэлх нутгаар амьдардаг байжээ. Тахь аюулд нүүрлэсэнтэй адил хулан ч бас аюулд багагүй өртөж байгаа зүйл юм. Сүүлийн 70 жилийн хугацаанд гэхэд л өөрийн тархан суурьшдаг байсан газар нутгийн тэн хагасыг алджээ. 1994 оны байдлаар 30,000-с 60,000 хүртэл байсан хулан 2003 он гэхэд 20,000 болж буурчээ. Эдгээр тоо нь нарийн статистик биш боловч 2009 онд 14,000 хулан хорогджээ. 1953 оноос хойш хуланг

хамгаалалтад авсан боловч Монголд хуланг хулгайгаар агнаж, махыг нь хүнсэнд хэрэглэж ирсэн нь тодорхой юм. Хуланг хүнсний хэрэгцээнд агнадаг хэдий ч нүүдэлчид өөрсдийн үржүүлж буй мал сүргийн бэлчээр нутгийн гол өрсөлдөгч амьтан гэж үзэх хандлага ч байдаг.

Говь цөлд амьдардаг хулан нь амьдрах, тэсвэрлэх маш гайхалтай чадвартай. Тал хээрийн өвсөөр хооллоод зогсохгүй, ургамал, сөөг, шүүслэг ургамал (*Zygophyllaceae*)-аар хооллодог. Ширгэсэн гол, горхи булагт нүх гарган ундаалдаг ба бусад амьтад ч ундаалах боломж олгодог байна.

Өөрийн ухаж ус гаргаж авсан нүхэн дээр буй говийн хулан.



Байгаль хамгаалал нь эдийн засгийн хүчин зүйл болох нь

Орон нутгийн ард иргэдийн зөвшөөрөлгүйгээр (ихэнх тохиолдолд тэд эдийн засгийн ашиг тусыг нь хүртэж байдаг) байгаль хамгаалах төсөл нь тогтвортой хэрэгжиж чадахгүй юм. Ийм ч учраас олон улсын тахь групп нь байгаль хамгаалагчийн гэр бүлээс авхуулаад орон нутгийн ард иргэд, төрийн албаныхныг хөтөлбөртөө татан оруулж байна. 2016 онд бид орон нутгийн захиргааны байгаль хамгаалагч нарыг чадавхжуулах ажлын байрны нөхцлийг сайжруулах болон орчны бүсийн Бугат сумын сургуулийн дэд бүтцийг дэмжих, Ховд аймгийн Алтай суманд байгаль хамгааллын мэдээллийн төв барихаар төлөвлөж байна. Дэд бүтэц сул хөгжсөн энэхүү бүсэд эко аялал жуулчлалыг хөгжүүлснээр орлого бий болгохыг аймаг, сумын төрийн албаныхан дэмжжээ хамтран ажиллахыг эрмэлзэж байгаа юм. Тэхийн уугуул нутгийг үзэх, сэргээн нутагшиж байгаа сүргүүдийг сонирхох, монголын нүүдэлчдийн ахуй соёл, өргөн уудам, гайхамшигт нутагтай танилцах нь үнэхээр сэтгэлд үлдэхүйц аялал бөгөөд ба экологийн хувьд уул уурхайн ашиглалтаас ч илүү тогтвортой орлогын эх үүсвэр юм.




Олон улсын тахь групп 2016 онд говь нутагруу аялах санал болгож буй бөгөөд аяллыг олон улсын тахь группын ТУЗ-ын гишүүн ахлах ба бидэнтэй хамт аяласнаар олон улсын тахь группт хувь нэмрээ оруулж буй хэрэг юм. Аяллын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг та манай вэб доорх хуудаснаас авах боломжтой:

www.savethewildhorse.org

ХАМГААЛЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

Төв Азийн тал хээр, говь, уулархаг газар нутагладаг амьтад



Зэрлэг амьтад чөлөөтэй нэвтрэх боломж бий болгох

Амьтад устан үгүй болж буй өнөөгийн гол шалтгаан нь амьдрах орчныг доройтуулж устгаснаас болж байна. Аюулд өртсөн байгаа олон төрөл зүйл амьтдыг урт хугацаанд оршин тогтноулахын тулд амьдрахад таатай орчин, газруудыг холбож өгөх явдал юм. Нүүдлийн шилжин суурьших чадвар өндөртэй талын амьтдын хувьд маш их зай талбай, газар нутаг хэрэгтэй.

Тэдний нүүдэллэх зай талбайг хязгаарлаж, хашаа барих, төмөр замын шугам татах, зам барих эсвэл суурьшмал аж ахуй бий болгох буюу үйлдвэржих зэргээс шалтгаалан тэд ховор тохиолдох ус унд, өвс ногоогоор хангагдах нөөцөөс холдож, тусгаарлагдснаар амьдралын хэмнэл өөрчлөлт ордог. Тийм ч учраас тэдний нүүдэллэх зам, жимийг мэдэж жилийн турш хамгаалж байх нь чухал юм.



ITG INTERNATIONAL TAKHI GROUP

Эрхлэн гаргасан

Олон улсын тахь групп
Монгол салбар
Байгаль ордон 38
Улаанбаатар
Утас: +976 11 362 064
itgmon@gmail.com

Худалдаа Хөгжлийн Банк
Данс: 499 114 883